



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 20 дугаар хурлын тэмдэглэлд:

4. Хотын стандарт, хяналтын газраас 2023 онд хийсэн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх танилцуулгыг Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдүлам танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1. Хяналт шалгалтын давхардалыг арилгах зорилгоор Хяналт шалгалт хийх нийтлэг журамд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хамтарсан шалгалтын удирдамж батлах, бланкны загвар батлуулах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т;


2. Шугам сүлжээний болон хяналт шалгалтын нэгдсэн мэдээллийн цахим системийг бий болгон тодруулга болон давхцал мөн хяналт шалгалтын түүх, хамгаалалтын зурвасын зөрчлийг тогтмол хянадаг болгох ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газар (Б.Давааням)-т;

3. Нийслэлийн Засаг даргаас Засгийн газрын сайд нартай байгуулж буй хамтран ажиллах гэрээнд тухайн жилийн хяналт шалгалтын объект болон чиглэлийг тодорхой тусгуулж, хэрэгжилтэд тухай бүрд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т;

4. Хяналт шалгалтад шаардагдах мэдээ мэдээллийг нэгдсэн цахим системээс татан авах ажлыг салбар яамтай хамтран шуурхай зохион байгуулахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газар (Б.Давааням)-т;

5. Барилга, Дэд бүтцийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулж, танилцуулахыг Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдүлам)-т тус тус үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1110200475